



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/87

Арвайхээр

**Газар ашиглалтын зориулалтад  
өөрчлөлт оруулах тухай**

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 3.4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар баг Т.Намнансүрэнгийн 1 дүгээр гудамж 100 тоотод байрлах Өв гурван лут ХХК (3562514)-ийн эрүүл мэндийн байгууллагын зориулалттай 480м<sup>2</sup> газрын зориулалтыг 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалттай болгон өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100186



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/84

Арвайхээр

### Шагнал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2019 оны А/788 дугаар захирамжаар баталсан “Аймгийн Засаг даргаас олгох шагналын журам”-ын 2.5, 5.9 дахь заалтыг тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2021 онд “Улсын хошой аварга малчин өрх”, “Улсын аварга малчин өрх”, “Улсын аварга саальчин”, “Улсын аварга тариаланч”-аар, 2020 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр таван төрлийн малаар аймагтаа тэргүүлж “Аймгийн манлай малчин”-аар шалгарсан хавсралтанд нэр бүхий малчдад хүндэтгэл үзүүлж, дурсгалын зүйлээр шагнасугай.

2. Шагналд шаардагдах 3,800,000 (гурван сая найман зуу мянга), өргөмжлөлийн зардалд 1,600,000 (нэг сая зургаан зуун мянга), шагнал гардуулах үйл ажиллагааны зардал 4,405,700 (дөрвөн сая дөрвөн зуун таван мянга долоон зуу), нийт 9,805,700 (есөн сая найман зуун таван мянга долоон зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй..

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100184